

**Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газраас зөвлөмж,  
акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах  
аяны хүрээнд хийсэн ажлын тайлан**

2017.11.24

Өлгий.

**Ерөнхий зүйл.**

Үндэсний аудитын газраас 2017 оны 8 дугаар сард гаргасан зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг хангуулах аяны хүрээнд Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газраас “Аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг хангуулах ажлын төлөвлөгөө”-г боловсруулан, тэргүүлэх аудитороор батлуулж, хэрэгжилтийг хангуулах талаар тодорхой ажлуудыг хэрэгжүүлж ажиллалаа.

Ажлын төлөвлөгөөнд нийт 10 заалт бүхий ажлыг 2017 оны 9 сарын 01-нээс 10 сарын 30-ны хооронд хэрэгжүүлэхээр төлөвлөж, төлөвлөгөөг аудитын алба хариуцсан ахлах аудиторуудад хариуцуулж, биелэлтэнд аудитын менежер, тэргүүлэх аудитор нар давхар хяналт тавьж ажиллав.

Ажлын төлөвлөгөөнд нийт 10 заалт бүхий ажил төлөвлөсний дотор өнгөрсөн оноос шилжиж ирсэн болон тайлант онд хийсэн аудитаар өгсөн хэрэгжих хугацаа болсон зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулах арга хэмжээ авах, хэрэгжилтийг давтан шалгаж, үр дүнг баримтжуулах, хугацаа хэтэрсэн, барагдахгүй байгаа төлбөрийн актуудыг судалж, хуулийн байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх, зөвлөмж, акт, албан шаардлагын мөрөөр аудитын үр өгөөжийг төлөвлөх, хэрэгжсэн үр өгөөжийг бүртгэлд тусгах, тооцоолж үр дүнг баримтжуулах, аудитын дүнгээр хүргүүлсэн хариуцлага тооцуулах санал, хуулийн байгууллагад шилжүүлсэн асуудлын хэрэгжилтийг авч, баримтжуулах зэрэг асуудлыг тусгасан.

Аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг хангуулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг газрын 7 хоног бурийн өглөөний шуурхай хурлаар авч хэлэлцэж, аудиторууд үүрэг чиглэл өгч ажиллав.

Завсарын аудитын хугацаанд зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг тухайн байгууллагуудаас давтан шалгаж, үр дүнг тооцох ажил хийгдэж байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 1350 тоот албан бичгээр Төсвийн захирагч наарт хүргүүлсэн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах зөвлөмжийг төсвийн төвлөрүүлэх захирагч наарт мэдээлэх, байгууллагын мэдээллийн самбарт тавьж сурталчлан таниулах арга хэмжээ авч ажиллаа.

**Нэг.Тайлант оны эхний 11 сарын зөвлөмж, акт, албан шаардлагын бүртгэл, хэрэгжилтийн дүнгийн талаар:**

**1.1. Зөвлөмжийн бүртгэл, хэрэгжилт үр дүнгийн талаар:**

Эхний хагас жилийн статистик мэдээгээр авч үзвэл өмнөх оноос шилжиж ирсэн 15 зөвлөмж байгаа ба тайлангийн хугацаанд хийсэн аудитын дүнгээр 46 зөвлөмжийг шинээр бүртгэж, үүнээс 35 зөвлөмжийн хэрэгжилтийг хангулж, 26 зөвлөмж дараагийн улиралд шилжсэн байна.

Харин 11 дүгээр сарын эцсийн мэдээгээр нийт 76 заалт бүхий зөвлөмж бүртгэлтэй байгаагийн 15 нь өмнөх оноос шилжиж ирсэн зөвлөмж, 61 нь тайлант оны зөвлөмж байна.Үүнээс:

- Санхүүгийн тайлангийн аудитаар 40,
- Гүйцэтгэлийн аудит 24,
- Нийцлийн аудитаар 12 зөвлөмж тус тус өгөгдсөн байна.

Нийт зөвлөмжийн 78,9 хувь буюу 60 нь хэрэгжсэн, 21,1 хувь 16 буюу нь хэрэгжих шатанд байна.Үүнээс 10 зөвлөмжийн хэрэгжих хугацаа болоогүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитын 40 зөвлөмжийн 37 буюу 92,5 хувь нь хэрэгжсэн, 6 буюу 7,5 хувь нь хэрэгжих шатанд байна.

Гүйцэтгэлийн аудитын 24 зөвлөмжийн 12 нь хэрэгжсэн, 3 нь хэрэгжих шатанд, 9 нь хэрэгжих хугацаа болоогүй зөвлөмж байна.

Нийцлийн аудитын 12 зөвлөмжийн 11 нь хэрэгжсэн, 1 нь хэрэгжих шатанд байна.

**Дүгнэлт, цаашид авах арга хэмжээ:**

1.Хэрэгжих хугацаа болсон зөвлөмжүүдийг ондоо багтаан хэрэгжилтийг нь хангуулах арга хэмжээ авч ажиллах.

2.Зөвлөмжийн үр дүнгээр бий болсон аудитын үр өгөөжийг бүртгэж баримтжуулах.

**1.2. Төлбөрийн актын бүртгэл, хэрэгжилт үр дүнгийн талаар:**

Эхний хагас жилийн статистик мэдээгээр өмнөх оноос шилжиж ирсэн 23,2 сая төгрөгийн акт бүртгэлтэй ба тайлангийн хугацаанд хийсэн аудитын дүнгээр 73,7 сая төгрөгийн актыг шинээр бүртгэж, үүнээс 29,7 сая төгрөгийн актыг барагдуулж, 67,2 сая төгрөгийн акт дараагийн улиралд шилжсэн байна.

2017 оны 11 дүгээр сарын эцсийн мэдээгээр аудитын дүнгээр нийт 49 актаар 122,6 сая төгрөгийн төлбөрийн акт бүртгэлтэй байна. Үүнээс өмнөх оноос шилжиж ирсэн 23,2 сая төгрөгийн 5 акт, тайлант онд хийсэн аудитаар 99,4 сая төгрөгийн 44 акт байна.

- Санхүүгийн тайлангийн аудитаар 71,9 сая төгрөгийн 30 акт,

- Гүйцэтгэлийн аудитаар 25,1 сая төгрөгийн 14 акт,
- Нийцлийн аудитаар 25,6 сая төгрөгийн 6 акт бүртгэлтэй байна.

Акт тогтоосон зөрчлийн нийт мөнгөн дүнгээр авч үзвэл 47,8 хувийг буюу 58,6 сая төгрөгийн, актын тоогоор нь авч үзвэл 76,0 хувийг буюу 38 актын хэрэгжилтийг хангуулаад байна. Өмнөх оноос шилжиж ирсэн 5,2 сая төгрөгийн 3 актын хэрэгжилтийг хангулсан.

- Санхүүгийн тайлангийн аудитын 46,5 сая төгрөгийн 28 актын хэрэгжилтийг хангулсан нь 64,7 хувийн биелэлттэй байна. Дэлүүн сумын Бүрэн дунд сургуулийн 17,2 сая төгрөгийн, Аймгийн ЗДТГ-ын 8,3 сая төгрөгийн актууд хугацаа хэтэрч барагдаагүй байна. Аймгийн ЗДТГ-ын 8,3 сая төгрөгийн акт хуулийн байгууллагад хянагдаж байгаа болно.
- Гүйцэтгэлийн аудитын 6,8 сая төгрөгийн 9 актын хэрэгжилтийг хангулсан нь 27,0 хувийн биелэлттэй. Боловсролын салбарын бүтэц орон тоо, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн аудитын 18,4 сая төгрөгийн барагдах хугацаа болоогүй актын үлдэгдэлийн 92,9 хувийг эзлэж байна.
- Нийцлийн аудитаар 5,4 сая төгрөгийн 2 актын хэрэгжилтийг хангулсан нь 21,0 хувийн биелэлттэй байна. Нийгмийн халамжийн сантай холбоотой өнгөрсөн оноос шилжиж ирсэн 18,0 сая төгрөгийн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитын 2,2 сая төгрөгийн актууд хугацаа хэтэрч актын үлдэгдэлийн 78,9 хувийг эзлэж байна.

Нийтдээ 65,4 сая төгрөгийн актын үлдэгдэлтэй байгаагийн 47,1 сая төгрөг нь барагдах хугацаа болсон актууд, 18,3 сая төгрөг нь барагдах хугацаа болоогүй актууд байна. Барагдах хугацаа болсон 47,1 сая төгрөгийн актын 18,0 сая төгрөгийн нь өмнөх оноос шилжиж ирсэн, 29,1 сая төгрөг нь тайлант онд хийсэн аудиттай холбоотой актууд байна. Барагдаагүй байгаа актууд:

- Санхүүгийн тайлангийн аудитын 25,5 сая төгрөгийн 2 акт,
- Гүйцэтгэлийн аудитын 18,3 сая төгрөгийн 5 акт
- Нийцлийн аудитын 20,2 сая төгрөгийн 4 акт бүртгэлтэй байна.

#### **Дүгнэлт, цаашид авах арга хэмжээ:**

- 1.Хэрэгжих хугацаа болсон төлбөрийн актуудыг ондоо багтаан барагдуулах арга хэмжээ авч ажиллах.
- 2.Төлбөрийн актын дүнгээр орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэр нэмэгдсэн хэмжээгээр аудитын үр өгөөжийг бүртгэж баримтжуулах.

### **1.3. Албан шаардлагын бүртгэл, хэрэгжилт үр дүнгийн талаар:**

Эхний хагас жилийн статистик мэдээгээр өмнөх оноос шилжиж ирсэн 5,1 сая төгрөгийн 1 албан шаардлага бүртгэлтэй ба тайлангийн хугацаанд хийсэн аудитын дүнгээр 750,1 сая төгрөгийн 25 албан шаардлага шинээр бүртгэгдэж, үүнээс 490,0 сая төгрөгийн 15 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, 265,2 сая төгрөгийн 11 албан шаардлага дараагийн улиралд шилжсэн.

2017 оны 11 дүгээр сарын эцсийн мэдээгээр нийт 79572,2 сая төгрөгийн 82 албан шаардлага бүртгэлтэй байна. Үүнээс 79567,1 сая төгрөгийн 81 албан шаардлага тайлант онд хийсэн аудитаар өгсөн албан шаардлага байна. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитаар 40,8 сая төгрөгийн 9 албан шаардлага,
- Гүйцэтгэлийн аудитаар 1339,6 сая төгрөгийн 35 албан шаардлага,
- Нийцлийн аудитаар 78191,8 сая төгрөгийн 38 албан шаардлага тус тус өгөгдсөн байна.

Нийт албан шаардлага бичигдсэн зөрчлийн дүнгээр авч үзвэл 2,3 хувийг буюу 1828,0 сая төгрөгийн, албан шаардлагын тоогоор авч үзвэл 29,2 хувийг буюу 24 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулаад байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн 5,1 сая төгрөгийн 1 албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулсан. Тайлант оны хэрэгжих хугацаа болоогүй 53 албан шаардлага нийт албан шаардлагын 91,3 хувийг эзлэж байна.

- Санхүүгийн тайлангийн аудитын 9,3 сая төгрөгийн 6 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулсан нь 22,7 хувийн биелэлттэй.
- Гүйцэтгэлийн аудитын 1313,4 сая төгрөгийн 9 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулсан нь албан шаардлагын мөнгөн дүнгээр нь авч үзвэл 98,0 хувийн, тоогоор нь авч үзвэл 25,7 хувийн биелэлттэй байна.

Орон нутгийн өмчийн "Суат" ХХК-ны 2016 оны үйл ажиллагаанд хийсэн аудитын 2,3 сая төгрөгийн 1 албан шаардлагын хэрэгжилт хангагдаагүй байгаа ба Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилтэд, Боловсролын салбарын бүтэц орон тоо, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн аудитын 25 албан шаардлагын хэрэгжих хугацаа болоогүй байна.

- Нийцлийн аудитаар 505,3 сая төгрөгийн 10 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулсан нь албан шаардлагын мөнгөн дүнгээр нь авч үзвэл 0,3 хувийн, тоогоор нь авч үзвэл 26,3 хувийн биелэлттэй харагдаж байна.

Гэхдээ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын хугацаа болоогүй 77686,5 сая төгрөгийн 28 албан шаардлага үлдэгдлийн 99,3 хувийг эзлэж байна.

**Дүгнэлт, цаашид авах арга хэмжээ:**

1.Хэрэгжих хугацаа болсон албан шаардлагыг ондоо багтаан хэрэгжилтийг нь хангуулах арга хэмжээ авч ажиллах.

2.Албан шаардлагын дүнгээр бий болсон аудитын үр өгөөжийг бүртгэж баримтжуулах.

**1.4. Хариуцлага тооцуулах санал, бүртгэл, хэрэгжилт үр дүнгийн талаар:**

Тайлант онд хийсэн аудитын дүнгээр зөрчил гаргасан 55 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлсэн байна.

- Санхүүгийн тайлангийн аудитаар 28 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, холбогдох байгууллагуудаас авсан арга хэмжээг албан бичгээр авч баримтжуулан хэрэгжилтийг 100 хангуулав.
- Гүйцэтгэлийн аудитаар Өлгий сумын ЗДТГазар, Боловсролын салбарын бүтэц орон тоо, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн аудитаар 2 албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлж, холбогдох байгууллагуудаас авсан арга хэмжээг албан бичгээр авч баримтжуулан хэрэгжилтийг 100 хангуулав.
- Нийцлийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар аймгийн Засаг даргад 25 албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжих хугацаа болоогүй байна.

**Дүгнэлт, цаашид авах арга хэмжээ:**

1.Хариуцлага тооцуулах саналын хэрэгжилтийг хугацаанд хангуулж, баримтжуулах.

**ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН